

“Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц,  
тайлагнах журам”-ын хоёрдугаар хавсралт

Регистрийн дугаар: 8488908

Хаяг: УБ, СБД, 8-р хороо, Тусгаар тогтнолын ордон

Шуудангийн хаяг:

Утас: 77444152 Факс:

**МОНГОЛ АРДЫН НАМЫН  
2025 ОНЫ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
/СТРАТЕГИ АКАДЕМИ НЭГТГЭСЭН/**

Хянаж хүлээн авсан Байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

## МОНГОЛ АРДЫН НАМ

"Тусгаар тогтнолын ордон"  
Улаанбаатар-14200, Монгол улс  
Утас/Факс: +976-77444158  
Цахим шуудан: contact@mpp.mn  
Цахим хуудас: www.nam.mn

2026.02.09 № 27  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Санхүүгийн тайлан хүргүүлэх тухай

Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12, 36 дугаар зүйлийн 36.14 болон 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Ардын Намын 2025 оны жилийн санхүүгийн тайланг гарган хүргүүлж байна

Монгол Ардын Намын нэгтгэсэн болон Удирдах Зөвлөлийн Ажлын алба, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, Стратеги академийн 2025 оны санхүүгийн тайлан, намын үйл ажиллагааны товч тайланг хавсаргав.

Хавсралт ... хуудас.

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Я.СОДБААТАР



МОНГОЛ  
АРДЫН НАМЫН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

МОНГОЛ АРДЫН НАМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
ҮЗҮҮЛЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Улс төрийн намын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14, 37 дугаар зүйлийн 37.2, 37.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь :

1. Монгол Ардын Намын болон намын дэргэдэх судалгааны байгууллагын /Стратеги академи/ нэгтгэсэн 2025 оны жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг дор дурдсанаар баталсугай.

1.1. Нийт хөрөнгийг 31,482,478.2 /гучин нэгэн тэрбум дөрвөн зуун наян хоёр сая дөрвөн зуун далан найман мянга хоёр зуу/ төгрөгөөр, үүнээс эргэлтийн хөрөнгийг 744,379.9 /долоон зуун дөчин дөрвөн сая гурван зуун далан есөн мянга есөн зуу/ төгрөгөөр, эргэлтийн бус хөрөнгийг 30,738,098.2 /гучин тэрбум долоон зуун гучин найман сая ерэн найман мянга хоёр зуу/ төгрөгөөр;

1.2. Өр төлбөрийн нийт дүнг 2,131,176.2 /хоёр тэрбум нэг зуун гучин нэгэн сая нэг зуун далан зургаан мянга хоёр зуу/ төгрөгөөр;

1.3. Эзэмшигчийн өмчийг 29,351,301.9 /хорин есөн тэрбум гурван зуун тавин нэгэн сая гурван зуун нэгэн мянга есөн зуу/ төгрөгөөр;

1.4. Үйл ажиллагааны орлогыг 5,709,337.0 /таван тэрбум долоон зуун есөн сая гурван зуун гучин долоон мянга/ төгрөгөөр;

1.5. Үйл ажиллагааны зардлыг 6,347,292.2 /зургаан тэрбум гурван зуун дөчин долоон сая хоёр зуун ерэн хоёр мянга хоёр зуу/ төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монгол Ардын Намын 2025 оны жилийн санхүүгийн тайланг Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлэхийг Санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан Ж.Чинболдод зөвшөөрсүгэй.

ХУУЛБАР ҮНЭН.

УЛС ТӨРИЙН АХЛАХ  
АЖИЛТАН



Д.БАЛДАНГОМБО



## МОНГОЛ АРДЫН НАМ

"Тусгаар тогтнолын ордон"  
Улаанбаатар-14200, Монгол улс  
Утас/Факс: +976-77444158  
Цахим шуудан: contact@mpp.mn  
Цахим хуудас: www.nam.mn

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

2026.02.09 № 28

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### МОНГОЛ АРДЫН НАМЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Ардын Намын Бага хурлын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор намын Санхүүгийн дотоод аудитораар томилогдон ажиллаж байна.

Монгол Ардын Намын 2025 оны жилийн санхүүгийн тайланд Улс төрийн намын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14-д заасны дагуу намын Удирдах Зөвлөлийн Ажлын алба, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн санхүүгийн тайлан болон намын дэргэдэх судалгааны байгууллагын /Стратеги академи/ тайланг нэгтгэсэн байна.

#### 1. Санхүүгийн тайлангийн талаар:

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө оны эхэнд 328,364.6 мянган төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст 180,031.8 мянган төгрөг болж 148,332.8 мянган төгрөгөөр буурчээ.

Авлага оны эхэнд 880,736.8 мянган төгрөг байсан бол авлага бууруулах арга хэмжээ авч ажилласны үр дүнд 394,153.8 мянган төгрөгөөр бууруулж 486,583.0 мянган төгрөг болжээ.

Урьдчилж төлсөн зардал 9,028.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болж тайлант хугацаанд 7,670.2 мянган төгрөгөөр есжээ.

Бараа материалын үлдэгдлийг 10,636.8 мянган төгрөгөөр бууруулан 53,688.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөөгүй байна.

Нийт үндсэн хөрөнгө /биет бус хөрөнгө орсон/ оны эхэнд 31,479,279.2 мянган төгрөг байсан бол 160,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 2,263.2 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасаж, 739,077.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж 30,738,098.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Татвар, НДШ-ийн өр төлбөрийг 592,328.0 мянган төгрөгөөр бууруулж 401,287.0 мянган төгрөгийн өртэй байна.

Бусад богино хугацаат өр төлбөр 1,729,889.3 мянган төгрөг болж 62,203.9 мянган төгрөгөөр буурсан.

Өмчийн дүн тайлант хугацаанд 632,102.5 мянган төгрөгөөр буурч 29,351,302.0 мянган төгрөг болсон байна.

## 2. Орлого, зардлын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогод намын гишүүдийн татварын 38,9 мянган төгрөг, Бага хурал болон Удирдах Зөвлөлийн гишүүний хураамжийн 1,093,748.0 мянган төгрөг, мөнгөн хандив 310,149.0 мянган төгрөг, төрийн санхүүжилтийн 2,819,790.6 мянган төгрөг, намын өөрийн орлого буюу оффис, заал, зогсоолын түрээсийн 1,409,532.4 мянган төгрөг, банкны хүүгийн 6,178.1 мянган төгрөг, Стратеги академийн орлого 69,900.0 мянган төгрөг, нийт 5,709,337.0 мянган төгрөгийн орлогыг тусгажээ.

Үйл ажиллагааны зардалд ажиллагсдын зардал буюу цалин, байгууллагаас төлөх НДШ-ийн зардлын 3,878,560.0 мянган төгрөг, төрийн санхүүжилтийн зардлын 1,411,608.3 мянган төгрөг, үйл ажиллагааны урсгал зардлын 289,002.7 мянган төгрөг, элэгдлийн зардал 722,192.0 мянган төгрөг, бусад зардлын 45,929.2 мянган төгрөг, нийт 6,347,292.2 мянган төгрөгийн зардал тусгагдсан байна.

Үйл ажиллагааны бус орлогод 108.0 мянган төгрөгийн, үйл ажиллагааны бус зардалд 2,188.2 мянган төгрөгийн зардал тусгасан байна.

Тайлант хугацаанд 640,035.5 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнажээ.

Монгол Ардын Намын 2025 оны жилийн тайланг гаргахдаа “Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам”-ын гуравдугаар хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-ын дагуу дансны жагсаалтыг боловсруулан оны эхнээс мөрдөж ажилласан, мөн дээрх журмын дагуу үндсэн хөрөнгийн элэгдлийг Говь-Алтай, Орхон аймгаас бусад нь анх удаа бодож тайлагнажээ.

Намын санхүүгийн тайланг санхүү, нягтлан бодох бүртгэлийн Прософт программыг ашиглан гаргаж, оны эхний үндсэн хөрөнгө болон авлага, өр төлбөрийн дансны үлдэгдлийг журналын бүртгэлтэй тулгаж тохируулсан байна.

Санхүүгийн балансын данс, орлого зардал бүрийн нэгтгэсэн дүнг гүйлгээ баланс, журнал бүрээр тулгаж шалгасан болно.

Монгол Ардын Нам /8488908/ болон Сургалт, судалгаа, пиар, мониторингийн “Стратеги академи” ТББ /8131287/ тус тус Сангийн яамны Е-балансад шивж оруулжээ. Харин Сонгуулийн ерөнхий хороонд нэгтгэсэн тайланг хүрүүлжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 болон 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасан орлогыг заасан хэмжээнээс хэтрүүлэлгүй, хязгаарыг барьж ажилласан байна.

Нэгтгэсэн санхүүгийн Орлогын тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасан Стратеги академид олгосон санхүүжилтийг давхардуулалгүйгээр тохиргоо хийж тайлагнасан байна.

Монгол Ардын Намын 2025 оны жилийн санхүүгийн тайлан нь Улс төрийн намын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайд, Сонгуулийн ерөнхий хорооны хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/243/208 тогтоол, тушаалаар баталсан “Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам”-ын дагуу илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН ДОТООД АУДИТОР



Ц.НОРОВЖАМЦ

МОНГОЛ АРДЫН НАМ-ын  
2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн  
Санхүүгийн тайлангийн тухай мэдэгдэл

Монгол Ардын Намын дарга Н.Учрал, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан Ж.Чинболд бид тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.1 дэх заалтын дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр гаргасан санхүүгийн тайланд үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Тайлант хугацааны бүх үйл явдал, ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтад үндэслэсэн:
2. Тайлан, тодруулгад тусгасан санхүүгийн болон бусад мэдээллийг материаллаг хэмжээнд үнэн зөв тайлагнасан:
3. Санхүүгийн тайланг тайлант хугацаагаар тасалбар болгосон ба орхигдсон, давхардсан зүйл байхгүй:
4. Ажил гүйлгээг зөв ангилан бүртгэж, хөрөнгө, өр төлбөр, өмчийг санхүүгийн тайланд зохистой үнэлгээгээр тусгасан.

НАМЫН ДАРГА

Н.УЧРАЛ

Санхүүгийн асуудал хариуцсан  
удирдах ажилтан

Ж. ЧИНБОЛД



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

МОНГОЛ АРДЫН НАМ

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгрөг, мөнгөөр/

	Санхүүгийн байдлын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>			
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	328,364,641.35	180,031,771.35
1.2	Авлага	4	880,736,838.85	486,583,000.77
1.3	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5	1,357,822.27	9,028,000.00
1.4	Бараа материал	6	64,325,099.30	53,688,252.74
1.5	Бусад эргэлтийн хөрөнгө	7	15,048,963.00	15,048,963.00
1.6	Эргэлтийн хөрөнгийн дүн		<b>1,289,833,364.77</b>	<b>744,379,987.86</b>
1.7	Үндсэн хөрөнгө	8	31,401,536,689.15	30,685,112,041.19
1.8	Биет бус хөрөнгө	9	77,742,540.00	52,986,196.25
1.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө	10	-	-
1.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<b>31,479,279,229.15</b>	<b>30,738,098,237.44</b>
<b>1.11</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>32,769,112,593.92</b>	<b>31,482,478,225.30</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		-	-
2.1	Татвар,НДШ-ийн өр төлбөр	11.1	993,614,990.34	401,286,995.23
2.2	Богино хугацаат өр төлбөр	11.2	1,792,093,132.00	1,729,889,253.00
2.3	Богино хугацаат зээл		-	-
2.4	Богино хугацаат өр төлбөрийн дүн		<b>2,785,708,122.34</b>	<b>2,131,176,248.23</b>
2.5	Урт хугацаат зээл	12.1	-	-
2.6	Нөөц / болзошгүй өр төлбөр/	12.2	-	-
2.7	Бусад урт хугацаат өр төлбөр	12.3	-	-
2.8	Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
<b>2.9</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>2,785,708,122.34</b>	<b>2,131,176,248.23</b>
<b>3</b>	<b>ӨМЧ</b>		-	-
3.1	Өмч	13	22,973,194,447.88	22,973,194,447.88
3.2	Өмчийн бусад хэсэг	14	4,755,617,700.00	4,755,617,700.00
3.3	Хуримтлагдсан үр дүн		2,254,592,323.70	1,622,489,829.19
<b>3.4</b>	<b>НИЙТ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>29,983,404,471.58</b>	<b>29,351,301,977.07</b>
<b>3.5</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b>32,769,112,593.92</b>	<b>31,482,478,225.30</b>

НАМЫН ДАРГА

Санхүүгийн асуудал хариуцсан  
удирдах ажилтан

Н.УЧРАЛ

Ж.ЧИНБОЛД

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

МОНГОЛ АРДЫН НАМ

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгрөг, мөнгөөр/

д/д	Орлого, зардлын зүйл	Тодруулга	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>			
1.1	Намын гишүүний татвар		402,443,751.08	38,877.00
1.2	Сонгуульт гишүүний татвар		3,508,932,628.89	1,093,748,000.00
1.3	Мөнгөн хандив	15.1	89,786,290.00	310,149,000.00
1.4	Мөнгөн бус хандив	15.2	5,000,000.00	-
1.5	Төрийн санхүүжилт	15.3	-	2,819,790,600.00
1.6	Төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэг	15.4	-	-
1.7	Төслийн санхүүжилт	15.5	-	-
1.8	Намын өөрийн орлого	15.6	4,642,863,998.64	1,485,610,525.54
<b>1.9</b>	<b>Үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>		<b>8,649,026,668.61</b>	<b>5,709,337,002.54</b>
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны зардал</b>			
2.1	Ажиллагсдын зардал		5,963,437,138.34	3,878,560,033.78
2.2	Үйл ажиллагааны урсгал зардал	16.1	3,686,923,458.79	289,002,679.95
2.3	Төрийн санхүүжилтийн зардал	16.2	-	-
2.3.1	нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих сургалтын зардал		-	564,454,900.00
2.3.2	намын гишүүдийн болон иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалтын зардал		-	424,099,310.00
2.3.3	судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал		-	423,054,080.00
2.4	Сонгуулийн зардал	16.3	-	-
2.5	Бусад үйл ажиллагааны зардал		-	768,121,242.15
2.6	<b>Үйл ажиллагааны зардлын нийт дүн</b>		<b>9,650,360,597.13</b>	<b>6,347,292,245.88</b>
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн (1-2)</b>		<b>(1,001,333,928.52)</b>	<b>(637,955,243.34)</b>
3.1	Бусад олз	17	-	107,971.05
3.2	Бусад гарз	18	-	2,188,200.00
<b>4</b>	<b>Татварын өмнөх ашиг, алдагдал (3+3.1-3.2)</b>		<b>(1,001,333,928.52)</b>	<b>(640,035,472.29)</b>
5	Орлогын татварын зардал			
<b>6</b>	<b>Татварын дараах ашиг, алдагдал (4-5)</b>		<b>(1,001,333,928.52)</b>	<b>(640,035,472.29)</b>
<b>7</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны орлого, зардал</b>			
<b>8</b>	<b>Тайлант үеийн ашиг, алдагдал (6-7)</b>		<b>(1,001,333,928.52)</b>	<b>(640,035,472.29)</b>
<b>9</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	19		
<b>10</b>	<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (8+9)</b>			

НАМЫН ДАРГА

Санхүүгийн асуудал хариуцсан  
удирдах ажилтан

9020040816



Н.УЧРАЛ

Ж.ЧИНБОЛД

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ОНГОЛ АРДЫН НАМ

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгрөг, мөнгөөр/

№/д	зүйл	Өмч	Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	<b>2023 ОНЫ 12-Р САРЫН 31 -НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	22,973,194,447.88	4,755,617,700.00	3,032,001,692.51	30,760,813,840.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	223,924,559.71	223,924,559.71
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	(1,001,333,928.52)	(1,001,333,928.52)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7		-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	<b>2024 ОНЫ 12 -Р САРЫН 31 -НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	22,973,194,447.88	4,755,617,700.00	2,254,592,323.70	29,983,404,471.58
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	7,932,977.78	7,932,977.78
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	(640,035,472.29)	(640,035,472.29)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15		-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	<b>2025 ОНЫ 06 -Р САРЫН 30 -НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	22,973,194,447.88	4,755,617,700.00	1,622,489,829.19	29,351,301,977.07

НАМЫН ДАРГА

Н.УЧРАЛ

Санхүүгийн асуудал хариуцсан  
удирдах ажилтан

Ж.ЧИНБОЛД



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

МОНГОЛ АРДЫН НАМ

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгсөг, мөнгөөр/

д/д	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
<b>1</b>	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1.1	Намын гишүүний татвар	402,443,751.08	38,878.00
1.2	Сонгуульт гишүүний татвар	3,401,932,628.89	1,201,348,000.00
1.3	Иргэний өгсөн мөнгөн хандив	61,786,290.00	310,149,000.00
1.4	Хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандив	28,000,000.00	-
1.5	Төрийн санхүүжилт	-	2,819,790,600.00
1.6	Төслийн санжүүжилт	-	-
1.7	Өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар олсон орлого	4,467,327,944.45	1,712,008,719.56
<b>1.8</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>	<b>8,361,490,614.42</b>	<b>6,043,335,197.56</b>
1.9	Ажиллагсад төлсөн мөнгө	(5,403,212,687.83)	(4,453,904,437.23)
1.10	Ашиглалтын зардалд төлсөн	(590,931,113.71)	(274,092,300.00)
1.11	Төрийн санхүүжилтийн зардал	-	(1,411,608,290.00)
1.12	Хангамжийн зүйл худалдан авахад төлсөн	(300,613,356.16)	(2,271,818.40)
1.13	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө	(487,660,891.87)	(18,190,433.00)
1.14	Сонгуулийн зардал	-	-
1.15	Бусад	(2,348,773,589.54)	(31,440,788.93)
1.16	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>(9,131,191,639.11)</b>	<b>(6,191,508,067.56)</b>
1.17	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(769,701,024.69)</b>	<b>(148,172,870.00)</b>
<b>2</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
2.1	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		
2.2	Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан		
2.3	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		
<b>2.4</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
2.5	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(56,800,000.00)	(160,000.00)
2.6	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.7	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
<b>2.8</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>(56,800,000.00)</b>	<b>(160,000.00)</b>
<b>2.9</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн/2.4-2.8/</b>	<b>(56,800,000.00)</b>	<b>(160,000.00)</b>
<b>3</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
3.1	Гишүүдээс оруулсан хөрөнгө		
3.2	Банкнаас хүлээн авсан зээл		
3.3	Бусад		
<b>3.4</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
3.5	Банкны зээлд төлсөн		
3.6	Бусад		
<b>3.7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>3.8</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн/3.4-3.7</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>5</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ/1.18+2.9+3.8+4/</b>	<b>(826,501,024.69)</b>	<b>(148,332,870.00)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,154,865,666.04</b>	<b>328,364,641.35</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>328,364,641.35</b>	<b>180,031,771.35</b>

НАМЫН ДАРГА

Санхүүгийн асуудал хариуцсан  
удирдах ажилтан

Н.УЧРАЛ

Ж.ЧИНБОЛД